

“ЗЭТ ДИ ЭЛ” ХХК

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН
СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДАРЦАГТЫН
ОРДЫН ЗҮҮН ХОЙД ХЭСЭГ” НЭРТЭЙ
ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ УУРХАЙН
АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020815

2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... 3

- 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл 3
- 1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа 5
- 1.3. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц..... 5
- 1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө..... 6

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... 7

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 10

- 3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим 10
- 3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим..... 13

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 15

- 4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго 15
- 4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө..... 16
- 4.3. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө..... 19
- 4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... 19
- 4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө..... 20
- 4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө..... 20
- 4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө..... 20
- 4.8. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал 21
- 4.9. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр..... 22
- 4.10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 25
- 4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг
нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө 25

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1.	Төсөл хэрэгжих талбайн солбицол.....	3
Хүснэгт 2.	Уурхайн ажиллах горим.....	5
Хүснэгт 3.	Уурхайд хэрэглэгдэх усны хэрэгцээ.....	5
Хүснэгт 4.	Ил уурхайн 2026 оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	6
Хүснэгт 5.	Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл.....	10
Хүснэгт 6.	Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах	12
Хүснэгт 7.	Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл	13
Хүснэгт 8.	Гол сөрөг нөлөөлөл.....	14
Хүснэгт 9.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал	16
Хүснэгт 10.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 11.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	19
Хүснэгт 12.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
Хүснэгт 13.	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	20
Хүснэгт 14.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 15.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	21
Хүснэгт 16.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	22
Хүснэгт 17.	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 18.	Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь	25
Хүснэгт 19.	2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал .	26

ЗУРГИЙН ГАРЧИГ

Зураг 1.	Төсөл хэрэгжих талбайн байршил	4
Зураг 2.	Мониторингийн цэгүүдийн байршил.....	24

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл


Төслийн нэр:	“Дарцагтын ордын зүүн хойд хэсэг нэртэй төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Зэт Ди Эл” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9019046035, Регистрийн дугаар: 5297591, Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020815
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Эко интернэйшнл тауэр” 15 давхарт. Утас: 77189988

Төслийн байршил:

“Дарцагтын ордын зүүн хойд хэсэг” төмрийн хүдрийн орд нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон авто замаас баруун тийш 8 км, Даланжаргалан сумаас баруун хойш 18 км, Шивээговь сумаас 34 км зайд байршина.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих талбайн солбицол

Д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Өргөрөг			Уртгаг		
			градус	минут	секунд	градус	минут	секунд
1	MV-020815	398.8	45	57	11.61	108	53	01.69
2			45	57	11.61	108	51	21.7
3			45	58	11.61	108	51	21.7
4			45	58	11.61	108	53	01.69
Нийт		398.8						



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

1.2. Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа

Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим:

Уурхайн хүчин чадлыг жилд 310.0 мян.тн хүчин чадалтайгаар 13 жилийн хугацаанд ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан байна.

Дарцагтын зүүн хойд хэсгийн уурхай нь жил бүрийн 1-р сарын 1-ээс 12-р сарын 31-ний хооронд ажиллах бөгөөд жилд ажиллах боломжит 365 хоногоос нийтийн амралтаар амрах хоног, тоног төхөөрөмж, цаг агаарын саатал зэрэг хоногийг хасч тооцсоноор нийт 303 хоног ажиллахаар байна.

Хүснэгт 2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
1	Жилд ажиллах боломжит хугацаа	хоног	365
2	Жилд амрах баяр ёслолын өдрүүд	хоног	15
3	Тоног төхөөрөмж, цаг агаарын саатал	хоног	48
4	Жилд ажиллах хугацаа	хоног	303
5	Хоног дахь ээлжийн тоо	ээлж/хон	2
6	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12
7	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент		0.83
8	Жилд ажиллах ээлжийн тоо	ээлж/жил	606
9	Жилийн ажлын цагийн хэмжээ	цаг/жил	6,060

1.3. Уурхайн барилга байгууламж, дэд бүтэц

1.3.1. Уурхайн цахилгаан хангамж

Уурхайн гадаад цахилгаан хангамж Айраг-Даланжаргалангийн 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаас салбарлуулан уурхай руу татаж уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангахаар ТЭЗҮ-д тусгасан.

1.3.2. Уурхайн усан хангамж

Хүснэгт 3. Уурхайд хэрэглэгдэх усны хэрэгцээ

№	Үзүүлэлт	Норм	Хэмжээ	Хоног	Хоногийн усны хэрэглээ, м³	Жилийн усны хэрэглээ, м³	Норм
1	Унд ахуйн болон хэрэглээний ус	80 л/хоног	306 хүн /нийт ажилчин/	303	24.48	7417.44	А/301 дугаар тушаалын 12-р хавсралт /Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр/
2	Зам талбай	2 л /м²	9600 м²	43	19.20	825.6	А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын гудамж, зам, талбай
Нийт дүн					43.68	8243.04	

Уурхайд ашиглагдах хэрэгцээний усыг уурхайн талбайд гаргасан өөрийн эзэмшлийн гүний худгаас хангахаар төлөвлөсөн болно.

1.4. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

2026 оны Уулын ажлын төлөвлөгөөнд уурхайгаас /В/ зэргээр 119.02 мян.тн, боломжтой /С/ зэргээр 30.98 мян.тн, нийт үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээгээр (В+С) зэргээр 150.0 мян.тн хүдэр олборлохоор төлөвлөлөө. Олборлолтын үед нийт 1.9 сая.м³ хөрс хуулалтын ажил хийгдэхээр байна.

Хүснэгт 4. Ил уурхайн 2026 оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Улирал	Хүдэр		Хөрс	Уулын цул	Хөрс хуулалтын итгэлцүүр	
		мян.м ³	мян.тн			м ³ /м ³	м ³ /тн
1	I	3.2	12	340	343.2	3.2	28.33
2	II	13.7	51.5	670	683.7	13.7	13.01
3	III	19.9	74.5	700	719.9	19.9	9.40
4	IV	3.2	12	286.6	289.8	3.2	23.88
5	Нийт дүн	40.0	150	1996.6	2036.6	40.0	13.31

Ил уурхайд ТЭЗҮ-д тусгасны дагуу дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

- 1.7 м³ утгуурт багтаамжтай HYUNDAI фирмийн R320-LC маркийн урвуу утгуурт экскаватор
- 60 тонны даацтай Sinotruck A7 маркийн автосамосваль
- 32 тонны даацтай Sinotruck A7 маркийн автосамосваль
- TONLY TLS551 маркийн зам усалгааны машин
- 7.0 м³ –н шанаганы багтаамжтай HYUNDAI “HL780-9S” маркийн утгуурт ачигч
- 90 кВт хүчин чадалтай SHANTUI SD-23 маркийн бульдозер
- Туслах машин, механизм

Баяжуулалтын технологи:

2026 онд баяжуулах үйлдвэр хуурай соронзон аргаар 150.0 мян.тн хүдэр 27.25% агуулгатай 40.87 мян.тн металлтай анхдагч хүдэр баяжуулан, 70.0 мян.тн хүдэр хүдэр дэх металлын хэмжээ 35.25 мян.тн дундаж агуулга 50.22% -ийн агуулгатай бүтээгдэхүүн гаргахаар байна. Баяжуулсан хүдрийн гарц 46.8%, металл авалт 86.25% тай гаргахаар байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Орд газар байршиж байгаа талбай нь Хэнтийн уулархаг ба говийн мужийн завсрын бүсэд хамаарна. Газрын гадаргуу нь далайн түвшнээс дээш 900-1210 м-т өргөгдсөн байдаг.

Гадаргуугийн рельеф нь гол төлөв толигор, мөлгөрдүү дов толгод юм. Ордын төвийн хэсгээр дайрсан цахирын судал ба цахирын бүс нь 0.8-1.05 м-ийн өндөр хадан цохио үүсгэсэн байдаг. Ордын ойролцоо 2.0-7.0 км-ийн радиуст байрлах хужирлаг цайдам хөндий нь алсуур налуу заримдаа намгархаг, дэрснийх сондуулаар хүрээлэгдсэн байдаг.

Цайдам, хуурай нурууд нь бороо хур багатай зун, намрын цагт цагаан хужир шүүгээр бүрхэгдсэн байдаг. Эдгээр цайдмуудад Зайрмаг, Хужирт, Жаргалантын хөндийнүүд хамаарна. Эдгээр хөндийд нь Зайрмаг, Жаргалантын худаг байдаг ба худгаас жилийн дөрвөн улиралд хүн мал ундаалж байдаг.

Уур амьсгал: Нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд багтана. Ажиглалтаас үзэхэд улирал, сар, хоногийн температур нь эрс хэлбэлздэг, хур тунадас бага, хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард -12°C - 25°C , хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард $+20^{\circ}\text{C}$ $+22^{\circ}\text{C}$ байдаг. Дулааны улиралд 9 сарыг дуустал үргэлжилдэг. Хур тунадас бага унадаг, жилд дунджаар 160-180 мм хүрдэг. Үүний ихэнх хэсэг нь зуны улирлын сүүлч, намрын эхээр бороо ордогтой холбоотой ба өвөлд дунджаар 23-27 мм хур тунадас унадаг. Эх газрын баруун хойноос чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3 м.сек хүртэл хурдаж шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилдаг.

Ус зүй: Төв азийн гадагшаа урсгалгүй ай савд багтах усан сүлжээ муу хөгжсөн нутаг юм. Шорвог устай жижиг нуурууд, хужирлаг цайдам, хөндий бүхий хотгоруудтай. Зуны улирлын сүүлч, намраар үргэлжилсэн ширүүн борооны дараа хөндий, хуурай сайруудаар хэмхдэс чулуулаг зөөвөрлөсөн түр зуурын булингартай үерийн ус урсдаг. Нутаг дэвсгэрийн хүрээнд худаг, шанд харьцангуйгаар элбэг. Талбайгаас зүүн урагш 2 км орчимд худаг байх бөгөөд усны ундарга нь 0.2-0.8 л/сек.

Үүнээс гадна хүн, малын ундны усыг гүний худгаас авч хэрэглэдэг ба удаан хугацаагаар хэрэглээгүй дарагдсан буюу усгүй худаг, шандууд ч тааралдана. Гэвч эдгээрийн ихэнх нь эрдэсжилт ихтэй тул ундны усны хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй боловч техникийн хэрэгцээнд ашигладаг.

Гидрогеологи: MV-020815 талбай хамрагдах нутаг нь нам уулсын бүс нутаг нь Чойрын хотгорын зүүн хил болох Дарцаг толгойн ус хагалбарын салбар уулсыг хамран оршдог. Хайгуулын талбайн хүрээнд геологи-гидрогеологийн бүрэлдэхүүний хувьд нас, найрлагаараа янз бүр метаморф, бялхмал, интрузив гаралтай ус агуулагч болон ус дамжуулагч чулуулгууд ялгагдсан. Талбайн геологийн зүсэлтэд ус үл нэвтрүүлэгч шинж чанартай, региональ болон локаль биет, давхарга ялгагдаагүй байдаг.

Газрын доорх ус нь ан цавын төрлийн ус бөгөөд түүний тэжээлийн үндсэн эх үүсвэр нь тус нутагт ховор унадаг агаарын хур тунадасны ус байна. Талбайд тархсан 0.4-1.0 км өргөнтэй нарийн зурвас хэлбэртэй дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны тархалтын хэмжээ маш бага, түүний зузаан нэг хоёр м-ээс хэтрэхгүй. Дөрөвдөгчийн хурдаст газрын доорх ус хуримтлагдах боломж бага, харин хур тунадасны тэжээлийн усыг дамжуулах, доод уст цогцолборт шүүрүүлэх, нэвчүүлэх үүрэг гүйцэтгэдэг гэж үзэж болно. Ордын геологи, гидрогеологийн судалгааны ажлын үр дүн, газрын доорх ус бүрэлдэх нөхцөл, усны хөдөлгөөн, литологи-стратиграфийн төрлүүдэд ус агуулагдах байдлаар талбайд доорх уст давхарга, цогцолбор ялгасан. Үүнд:

- Дөрөвдөгчийн ангилагдаагүй сэвсгэр хурдас дахь уст давхарга
- Дунд-дээд юрагийн уст цогцолбор
- Неопротерзойн Оорцог формацийн уст цогцолбор
- Гүний интрузив чулуулаг дахь уст цогцолбор

Дөрөвдөгчийн ангилагдаагүй хурдас дахь уст давхарга нь талбайд тархсан бүх насны хурдсыг хучиж, түр зуурын урсацтай сайр, нуурын хотгор, уул толгодын хоорондох хотгорт тархсан байдаг. Уг хурдсыг гарал үүслээр нь аллюви, аллюви-пролювийн, делюви, нуурын, гэж хувааж болно.

Хөрс, ургамал: Хөрс ургамлын бүтэц нь өөрийн тархалт, зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, нам дор газарт цайвар шаргал, хужирлаг, толгодын эл хажуугаар хүрвэртэр өнгийн хөрсүүд ялгагдана. Хүрэн, хүрэн бор хөрс нь голдуу элсэнцэр агуулах ба хужирлаг цайвар шаргал хөрс нь аллювиаль, нуурын гаралтай шавар, шавранцраас тогтоно.

Шимт хөрсний үеийн зузаан нь 0.05-0.2м, хааяа 30-40 см хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархац маш сийрэг, хонхор хотгор газрууд толгодын хажуу бэл хэсэгт хур борооны дараа газар нь сэргэж ургамлын тархац ихэсдэг.

Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч нэр төрлийн өвс ургамал нь хялгана агь таана, хөмөл, шарилж зэрэг болно. Дов толгодын нуруу хажуу хэсгээр алтан харгана, дэрс цайдам хөндийн хэсэгт бударгана, дэрс ургадаг.

Бүс нутгийн дэд бүтэц: Бүс нутагт гадаад, дотоодын компаниуд томоохон орд илрэлүүдийн нөөц баялгийг тогтоох, нэмэгдүүлэх зорилгоор геологи-хайгуулын ажил эрчимтэй явуулж байгаа бүс нутаг юм. “Монголын Алт” ХХК-ний ашиглаж байгаа Цементийн үйлдвэр, өндөр хүчдэлийн 10 квт-ийн шугамыг Даланжаргалан сумаас татаж, сайжруулсан шороон замаар 25-р зөрлөгтэй холбогдсон тул дэд бүтцийн хамгийн таатай нөхцөлтэй болно.

Нутаг дэвсгэрийн хэмжээнд үндсэндээ нутгийн малчин ардууд нүүдэллэн амьдардаг. Дийлэнх нь мал аж ахуй эрхлэх бөгөөд үйлдвэр худалдаа, газар тариалан хөгжөөгүй. Малын ихэнх хувийг хонь, ямаа, үлдсэн хувийг адуу, үхэр эзэлнэ. Хүн ам тогтмол суудаг томоохон төв нь Даланжаргалан сум болон төмөр замын 25-р зөрлөг бөгөөд энд хүн эмнэлэг, бүрэн дунд боловсролын сургууль, холбооны болон банкны салбарууд, ШТС, жижиг үйлчилгээний

газруудтай. Харилцаа холбоо сайн хөгжсөн, тээврийн хэрэгслийн үндсэн төрөл нь төмөр зам, автомашин. Талбайн зүүн урд талд “МАК” ХХК-ны Цементийн үйлдвэр, талбайгаас баруун хойш 35 км-т Шивээ Овоогийн нүүрсний уурхай байрлана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Зэт Ди Эл” ХХК-ийн “Дарцагтын ордын зүүн хойд хэсэг нэртэй төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгааны арга, БОНХЯ-аас /хуучин нэрээр/ гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц зэргийг ашиглан хийж гүйцэтгэлээ.

3.1. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Хүснэгт 5. Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт										
Гадаргын усны өөрчлөлт										
Агаарын чанарын өөрчлөлт	х				х		х	х		
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х	х		
Геологийн тогтцын өөрчлөлт	х				х		х		х	
Зэрлэг амьтдын орон зай		х			х		х			х
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		х			х					х
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал		х			х		х			х
Эрдэс түүхий эдийн нөөц	х				х		х	х		
Эрчим хүчний нөөц										
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	х				х		х	х		
Хөрсний эвдрэл, бохирдол	х				х		х		х	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	х				х		х		х	

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Будаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	х				х		х		х	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	х				х		х			х
Орон нутгийн орлого нэмэгдэх	х				х		х	х		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х				х		х			х
Ажлын байр нэмэгдэх	х				х		х			х
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х				х		х			х
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	х				х		х			х
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх	х				х		х		х	
Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	х			х			х			х
Хүчтэй салхи, уруйн үер										
Дүн	17	3		1	19		19	5	6	9

Дээрх хүснэгтээс дүгнэхэд байгаль орчинд нөлөөлж болзошгүй шууд, урт хугацааны, буцалтгүй, бага зэргийн нөлөөлөл нэлээд хувийг эзэлж байна.

Үүнд:

- ✓ Агаарын чанарын өөрчлөлт
- ✓ Ургамлын бүтцийн өөрчлөлт
- ✓ Хөрсний элэгдэл эвдрэл
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт
- ✓ Агаарын бохирдол
- ✓ Хөрсний элэгдэл, бохирдол
- ✓ Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх
- ✓ Орон нутгийн орлого нэмэгдэх
- ✓ Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
- ✓ Ажлын байр нэмэгдэх
- ✓ Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
- ✓ Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх
- ✓ Шороон зам, шилжилтээс болж хөрс эвдрэх
- ✓ Ахуйн хаягдал, хогийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах шавж үржих зэрэг байна.

Дээрх болзошгүй нөлөөллүүдээс харахад эдийн засаг, нийгмийн асуудалд уурхайн үйл ажиллагаа шууд, урт хугацааны, буцалтгүйгээр нөлөөлөх эерэг нөлөөтэй байна.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг.

Уг төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн “магадлан жагсаалт” хүснэгтэд түүний нөлөөллийн үр дагаврыг “муу”, “дунд”, “сайн” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 6. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон нөлөөллийн эрчим, үр дагаврыг магадлан жагсаах

Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Муу (бага)	Дунд	Сайн (их)
1.Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Түүх соёлын дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
Усан хангамж, газрын доорх усны горимд өөрчлөлт орох	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, орчны бохирдлын хяналтын сонгосон төхөөрөмж хир зэрэг зохимжтой				х
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
Уурхайн үйл ажиллагааны явцад гарах тоосжилтыг бууруулах асуудал хир зэрэг тусгагдсан				х
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай холбогдож гарах байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны үед усны нөөц хомсдох байдал		х		
Төсөл хэрэгжих үеийн хөрсний элэгдэл, эвдрэл				х
Үйлдвэрлэлийн осол, аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			х	
4.Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх			х	
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			х	
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)			х	
Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		х		
5.Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд болон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х

Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл

Төсөл хэрэгжих байршлын хувьд хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын археологийн олдворт газарт ямар нэгэн нөлөөлөл байхгүй.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, мөн үйл ажиллагаанаас гарах дуу чимээг багасгах талаар дунд зэргийн үр дагавартай байна.

Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийг хэрэгжүүлэх нийт ажлын явцад байгаль орчинд хөрсний элэгдэл эвдрэл, газар ашиглалтад хохирол учруулах зэрэг нөлөөлөл хүчтэй байна.

3.2. Гол сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Дарцагтын ордын зүүн хойд хэсэг” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хүрээнд төмрийн хүдэр олборлох, хуурай соронзон аргаар баяжуулах, тээвэрлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ. Иймд ил уурхайн байгаль орчны сөрөг нөлөөллийн асуудлыг авч үзэхдээ Леопольдын матрицын аргыг хэрэглэв.

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл

№	Үйл ажиллагааны хэлбэр Экологийн тогтолцоо	Эрэл хайгуул	Хөрс хуулах (хотхоны барилга, байгууламж)	Тэсэлгээ	Ил уурхайн олборлолт	Хуурай соронзон аргаар баяжуулах	Овоолго	Ачих тээвэрлэх	Бүгд
1	Агаар		2/3	9/9	2/2	8/8	3/3	4/5	28/30
2	Хөрс		2/5	10/10	3/3	3/3	6/6	2/3	26/30
3	Гадаргын ус								
4	Газрын доорх ус								
5	Ургамал		5/5	9/9	3/3	3/3	8/8	2/3	30/31
6	Ан амьтан		1/1	1/1				1/3	3/5
7	Усны амьтан, ургамал								
8	Геологийн тогтоц		1/1	9/9	8/8			1/1	19/19
9	Байгалийн үзэсгэлэн		1/1	5/5	2/2	1/1	1/1		10/10
10	Бэлчээр		2/2	5/5	3/3	4/4	6/6	1/1	21/21
11	Хүний эрүүл мэнд		5/6	4/5	9/9	8/8	1/2		27/30
12	Бүгд		19/24	52/53	30/30	27/27	25/26	11/16	164/176

Дээрх хүснэгтийн босоо багануудын нийлбэр дүнгээс үзвэл хөрс хуулах, тэсэлгээ хийх, нүх, карьер ухах, овоолго хийх, ачих тээвэрлэх явц нь агаар, хөрс, ургамал, хүний эрүүл мэнд

зэрэгт ихээхэн нөлөөлж болзошгүй нь харагдаж байна. Нөлөөлөлд хамгийн их өртөгч нь агаар, хөрс, ургамал зэрэг юм.

Нөлөөлөлд орох байдлаар ангилбал агаар 28/30, ургамал 30/31, хөрс 26/30, бэлчээр 21/21, хүний эрүүл мэнд 27/30 1-р ангилалд, геологийн тогтоц 19/19, байгалийн үзэсгэлэн 10/10 2-р ангилалд орж байна.

Хүснэгт 8. Гол сөрөг нөлөөлөл

№	Байгаль орчны хүчин зүйлс	Гол сөрөг нөлөөлөл
1	Газрын гадарга, хөрс	Уурхайн үйл ажиллагаа болон овоолгоор хөрс, ургамал нь бүр мөсөн устаж, дахин сэргээгдэхгүйгээр үхэжнэ.
2	Агаар	Төмрийн хүдрийг ачих, тээвэрлэх, овоолго үүсгэх зэрэг үйл ажиллагааны үед агаарын чанарт үзүүлэх нөлөө их байна. Энэ үед тоос, тээврийн хэрэгслээс гарах ШТМ-ын утаа агаарт дэгдэж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
3	Ургамал	Нийт талбайн ургамлан бүрхэвч устаж үгүй болно. Нөхөн сэргээгдэх байдал хязгаарлагдмал. Овоолго үүсгэх газрын ургамал мөн устаж үгүй болж ургамлын бүрхэвчийн хэмжээ, бэлчээрийн талбай багасна. Ургамлын нөхөн сэргээгдэх боломжийг судалж, хаягдал хаягдаагүй хэсгүүдийг нөхөн сэргээх шаардлагатай.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгах, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг тогтмол хянах зорилготой. Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино. Үүнд:

- ✓ Уурхайн үйл ажиллагаанд хамрагдаж байгаа талбайн хэмжээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангах,
- ✓ БОННҮнэлгээний заалтуудыг хэрэгжүүлэх,
- ✓ Байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамаарал, хамрах хүрээг тодорхойлох,
- ✓ Уурхайн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлан хэрэгжүүлэх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох,
- ✓ Орон нутагтай байгаль хамгаалах, дүйцүүлэн хамгаалах ажилд хамтран ажиллах,
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-т олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах,

4.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчин									
1	Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн ам орчимд болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Уурхайн гол болон тээврийн зам	км	50.0	1.6	50.0 x 40 удаа = 2 000.0	Зуны хуурай улиралд 7 хоногт 2 удаа	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2025
2		Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу	ОХШХ-д тусгав.				Жилд 2 удаа	
3		Тээврийн хэрэгслүүдэд оношилгоог тогтмол хийлгэж, тэдгээрт засвар үйлчилгээ хийх	Бүх тээврийн хэрэгслүүд	ш	-	-	Үйл ажиллагааны зардалд	Тогтмол	MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Гадаргын ба газрын доорх усны нөөц									
1	Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүрийн эхэнд гаргуулах	Уурхай	Үйл ажиллагааны зардлаар /тоолуурын заалтаар/				Жил бүрийн эхэнд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
2		Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх						Үйл ажиллагааны турш	
3		Хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөл авч, дүгнэлт гаргуулах, гэрээ байгвуулах		Гэрээний дагуу				2026 оны эхний улиралд	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4		Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	ОХШХ-д тусгав.				Улиралд 1 удаа, жилд 4 удаа	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018
5		Худгийн тохижилт, засвар хийх	Гүний худаг	-	-	-	ҮАЗ	2026 онд	БОНХАЖСайд, БХБСайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам
6		Ундны усыг цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулж ундны усны стандартад нийцүүлэх	Гүний худаг	ширхэг	1,500.0	1	1,500.0	2026 оны 2-р улиралд	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018
Хөрсөн бүрхэвч									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах	Овоолго	Үйл ажиллагааны зардлаас				Ашиглалтын явцад	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай Монгол улсын хууль MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. MNS 5916:2008 “Газар шорооны
		Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах	Шимт хөрсний овоолго						

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Уурхай орчим, тээврийн гол зам дагуу						ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”
Ургамлан нөмрөг									
1	Уурхайгаас олборлосон төмрийн хүдэр, хоосон чулуулгийн овоолго үүсгэх зэрэг ажлын үед ургамал устгах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөнө.	Нөхөн сэргээлтэд ашиглах хөрсний шимт хэсгийн овоолгыг стандартын дагуу тусгайлан овоолж, салхинд хийсэхээс хамгаалах.	Шимт хөрс, овоолгын талбай		Нөхөн сэргээлтийн зардлаар			Шимт хөрс хуулалтын үед, ашиглалтын явцад	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт. Хадгалалт MNS5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага
2	Уурхайн үйл ажиллагааны туршид тоосжилт үүсэх, энэ нь ойролцоох газрын ургамлын фотосинтезийн үйл ажиллагаанд нөлөөлөн ургалтын эрчмийг доройтуулах	Тоосжилтоос үүсэх дам нөлөөг багасгах үүднээс шаардлагагүй замуудыг хаах, усалгаа хийх, байнгын хяналт тавьж байх	Уурхайн карьер орчим, тээврийн зам дагуу		Үйл ажиллагааны зардлаар			Үйл ажиллагааны турш	Байгалийн ургамлын тухай хууль
2026 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлын дүн						3 500.0			

4.3. Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Төслийн ТЭЗҮ болон БОННУ-ний тайланд тусгасны дагуу төслийн 3 дахь жилээс нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ.								
1	Ногоон байгууламж байгуулах	Хөрс сайжруулах, мод бут тарих	Уурхайн ажилчдын байр орчимд орчны тохижилт хийх.			3 000.0	2026 онд	Газрын тухай хуулийн 56.6 Эдэлбэр газрын 10%-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.
Нийт						3 000.0		

4.4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Орон нутгаас ирүүлсэн саналын дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлыг хийж гүйцэтгэнэ.			1	10 000.0	10 000.0	2026 онд	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Орон нутгийн мэргэжлийн байгууллагаас зааж өгсөн газарт мод тарих, модны нүх ухах зэргээр хамтран ажиллана.		500 ш	10.0	5 000.0	2026 онд	Засгийн Газрын 2021 оны 350 дугаар тогтоол
Нийт						15 000.0		

4.5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 12. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2026 онд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй.							

4.6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд нэн даруй мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.

Хүснэгт 13. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2026 онд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй.								

4.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 14. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техник хэрэгсэлтэй харьцах үед гарч болзошгүй осол аваар	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол, гамшгаас урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажиллагсад	4	500.0	2 000.0	Улирал бүр /жилд 4 удаа/	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/130 дугаар тушаалын 1-р хавсралт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”
2		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны самбар байрлуулах	Уурхай	ХАБ-ын зардалд			2026 онд	УУХҮ-ийн сайд, ХНХСайдын 2019 оны А/231, А/368 дугаар

3		Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Уурхайн нийт ажиллагсад				Жилд 1 удаа	хамтарсан тушаалын хавсралт “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм” Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
4	Гал түймэр	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	Уурхайн ажилчдын байр, ажлын байрнуудад			1 000.0	2026 онд	
5	Тэсрэх бодис	Мэргэжлийн гэрээт байгууллагаар тэсэлгээний ажил гүйцэтгүүлэх	Тэсэлгээний ажлын үед	Гэрээнд заасан үнийн дүнгээр тэсэлгээний тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага хариуцан ажиллана.			ТЭЗҮ, гэрээний дагуу	MNS 4223 : 1994 Тэсрэх бодис Техникийн шаардлага УУХҮ-ийн сайд, ХНХСайдын 2019 оны А/231, А/368 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм”
		Тэсрэх бодисын тоо бүртгэлийг тогтмол хийх						
		Тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодлыг гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан аюулгүй болгох						
	Нийт			3 000.0				

4.8. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хүснэгт 15. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг тохижуулах	Уурхай	-	800.0	1	800.0	2026 онд	Хог хаягдлын тухай хууль
		Хог хаягдлын гэрээ байгуулж, орон нутгийн төвлөрсөн хогийн цэгт тогтмол тээвэрлүүлэх	Уурхай	сар	100.0	12	1,200.0	2026 онд	
2	Аюултай	Тэсрэх бодисын сав баглаа боодлыг гэрээт компанид хүлээлгэн өгөх	Уурхай	Гэрээнд заасны дагуу				2026 онд	
Нийт				2 000.0					


4.9. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаарын чанарын болон дуу шуугианы хэмжилт хийх, хөрсний болон усны шинжилгээ хийлгэх ажлыг төлөвлөсөн.

Хүснэгт 16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Агаарын чанар						
SO ₂ , NO ₂ , CO, Тоос,	Уурхайн ам орчим, тээврийн зам, ажилчдын байр орчим 3 цэгт	Жилд 2 удаа	Хавар, намар	SO ₂ - 22.5, NO ₂ -22.5, CO – 12.5, Тоос- 150.0	2 500.0	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Агаар бохирдуулагч бодисуудын ялгарлын хэмжээ	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүд	Жилд 1 удаа	1 удаа	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлаас		MNS 5013:2003 Бензин хөдөлгүүртэй автомашин, утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2003 Дизель хөдөлгүүртэй
Дуу шуугиан						
Дуу шуугиан, чичиргээ	Уурхайн талбай, тоног төхөөрөмж, ажлын байранд 3 цэгт	Хавар, намар	Жилд 2 удаа	1 удаагийн хэмжилт: 200.0	400.0	MNS4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000 Шуугианы норм, аюулгүй ажиллагаа
	Авто тээврийн зам дагуу	Хавар, намар	Жилд 2 удаа			MNS4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч						
Хөрсний механик бүрэлдэхүүн болон бохирдлын үзүүлэлтүүд /ялзмагийн агууламж, хөрсний орчин, карбонатын агууламж, хүнд металл/	Уурхайн тээврийн зам, тосгон орчим, ШТС 3 цэгт	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Хөрсний агрохими- 70.0 Хүнд металл- 80.0 Микробиологи- 50.0	600.0	MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 3297:2019 Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм хэмжээ
Усан орчин						

Хяналт-шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт ба арга, аргачлал
Унд ахуйн зориулалтаар ашиглах усны pH, TDS, нийт хатуулаг, исэлдэх чанар, Ca, Mg, Na, K, NH ₄ , нийт Fe, HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ , амт, үнэр, өнгө, тунгалаг чанар, эрдэсжилт г.м	- Унд-ахуйн ус	Улирал тутамд	Жилд 4 удаа	200.0	800.0	MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS ISO 5667-1 : 2002 Усны чанар. Дээж авах 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар MNS ISO 5667-3 : 2019 Усны чанар. Дээж авах. 3-р хэсэг: Усны сорьцтой харьцах ба сорьцыг тогтворжуулах
Усны ерөнхий химийн шинжилгээ / HCO ₃ , Cl, SO ₄ , NO ₂ , NO ₃ /	- Худаг, уст цэг	Хавар, намар	Жилд 2 удаа	150.0	600.0	MNS 4586:2024 Усан орчны чанар. Ерөнхий шаардлага
Хаягдал усны шинжилгээ	- Хаягдал ус цуглуулах цэг	Улирал тутамд	Жилд 4 удаа	150.0	600.0	MNS 4943:2015 Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага. MNS ISO 5667-10:2001 Усны чанар. Дээжлэлт, 10-р хэсэг: Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж
Нийт			5 500.0			



Зураг 2. Мониторингийн цэгүүдийн байршил

4.10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он					
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал		
1	УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	-					Ашиглалтын инженер, БО-ы мэргэжилтэн	
2	БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-ний зардлаар					Байгаль орчны мэргэжилтэн	
3	Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Байгууллагын ХАБ-ын зардалд					Уурхайн дарга, Захиргаа хүний нөөцийн алба, ХАБ	
4	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан байгаль орчныг хамгаалах, мэдлэг олгох зэрэг арга хэмжээг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар					Байгаль орчны мэргэжилтэн	

4.11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оришин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 18. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь

№	Ажлын нэр	Хэнд	Хариуцах эзэн	Хугацаа	Зардал мян.төг
1	Уурхайн үйл ажиллагааны талаар орон нутгийн мэргэжлийн байгууллагууд болон иргэд, олон нийтийг мэдээллээр хангах	Төслийн нөлөөллийн бүсийн иргэд, сумын иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд	Уурхайн дарга, БО-ы мэргэжилтэн	Төсөл хэрэгжих хугацаанд	500.0
2	БОМТ-ний хүрээнд хийсэн ажлуудын тайлагнал		Уурхайн дарга, БО-ы мэргэжилтэн	2026 оны 10 сард	500.0
Нийт					1 000.0

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 33.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Тухайн жилд хэрэгжүүлэх БОМТ-ний зардлыг бүрэлдэхүүн тус бүрээр дор хүснэгтэд харуулав.

Хүснэгт 19. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг	Нийт зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,500.0
2	Нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	3,000.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,000.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,000.0
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	5,500.0
9	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,000.0
2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		33,000.0